



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН САЙДЫН  
ТУШААЛ

2014 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 202

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Газрын тосны тухай хуулийн 8.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам”-ыг 1 дүгээр хавсралт, талбайн захиалгын хуудсыг 2 дугаар хавсралт, хайгуулын хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн хуудсыг 3 дугаар хавсралт, бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцлүүдэд өгөх саналын хуудсыг 4 дүгээр хавсралт, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил, зарцуулах хөрөнгийн хэмжээний хуудсыг 5 дугаар хавсралт, талбайн сонгон шалгаруулалтын үнэлгээний хуудсыг 6 дугаар хавсралт, сонгон шалгаруулалтын үнэлгээний харьцуулалтын хуудсыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. “Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Газрын тосны газар /Г.Өлзийбүрэн/-т даалгасугай.

Гурав. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Үйлдвэр худалдааны сайдын /хуучнаар/ 2008 оны 33 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.ГАНХУЯГ

Уул уурхайн сайдын  
2014 оны ... дугаар тушаалын  
хавсралт

## ГЭРЭЭЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ

УХА0380

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хайгуул, ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, захиалга хүлээн авах, үнэлгээ хийх, сонгон шалгаруулалтын дүнг гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Хайгуул, ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, захиалга ирүүлэх, хүлээн авах, татгалзах

2.1. Хайгуул, ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах:

2.1.1. Хайгуул, ашиглалтын талбайн нээлттэй сонгон шалгаруулалтыг газрын тос, уламжлалт бус газрын тосны төрөл тус бүрээр хуулийн 19.2, 20.1-д заасны дагуу зарлана.

2.2. Хайгуул, ашиглалтын талбайн захиалга ирүүлэх, хүлээн авах, татгалзах:

2.2.1. Хайгуул, ашиглалтын талбайн геологийн судалгааны багц материалыг Төрийн захиргааны байгууллага бэлтгэж, үнийг тогтооно.

2.2.2. Төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбогдуулан тухай бүр "Ажлын хэсэг", "Үнэлгээний хороо"-г байгуулна.

2.2.3. Энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу "хайгуул, ашиглалтын талбайн захиалга"-ыг бэлтгэж, талбайн захиалгын үйлчилгээний хөлс, багц материал худалдан авсан баримтын хамт Төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

2.2.4. "Хайгуулын талбайн захиалга"-ын үйлчилгээний хөлс хуулийн 34.5-д заасны дагуу 20000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

2.2.5. Захиалга Монгол хэл дээр байна. Гадаадын компани сонгон шалгаруулалтад оролцох бол захиалгын Англи хэл дээрх хувилбарыг давхар ирүүлж болно.

2.2.6. "Захиалга"-ыг дагалдах баримт бичиг нь гадаад хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн захиалгад холбогдох хэсгийг Монгол хэлэнд хөрвүүлсэн байна.

- 2.2.7. Захиалга нь эх хувь болон 3 (гурван) хуулбар хувь байх бөгөөд тус бүрийг “Эх хувь”, “Хуулбар хувь” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж тэдгээрийг багцалж, битүүмжилнэ.
- 2.2.8. Захиалга хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлсэн захиалгыг хүлээн авахаас татгалзах бөгөөд тогтоосон хугацаанд ирүүлсэн захиалгыг Төрийн захиргааны байгууллага акт үйлдэн Ажлын хэсгийн ахлагчид хүлээлгэн өгнө.
- 2.2.9. Захиалагч, Ажлын хэсгийн шаардсанаар захиалгатай холбогдолтой баримт бичгийг гаргаж өгнө. Мөн захиалгаас татгалзах саналыг Төрийн захиргааны байгууллагад өгч болно.
- 2.2.10. Тухайн зарласан талбайн бүх захиалга нь холбогдох хууль болон энэхүү журамд нийцээгүй тохиолдолд уг талбайг дахин нээлттэй зарлуулах хүсэлтийг Төрийн захиргааны байгууллагаас Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### 3. Захиалгыг судлах, хянан үзэх, шалгах, хэлэлцээ хийх, дүгнэлт гаргах

- 3.1. Ажлын хэсэг нь “хайгуул, ашиглалтын талбайн захиалга”-ын иж бүрдлийг энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу хянан үзэж, хүлээн авах эсэх тухай дүгнэлт гаргаж байгууллагын удирдлагад танилцуулан энэ тухай захиалагчид ажлын 5 өдрийн дотор багтаан бичгээр мэдэгдэнэ.
- 3.2. Захиалгыг хүлээн авсан тохиолдолд ажлын хэсэг захиалга хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 45 хоногийн дотор дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 3.2.1. Захиалагчийн эрх зүйн байдлыг нотлох баримт бичгүүдийг хянан үзэх, эрх бүхий байгууллагаас лавлагаа авах;
- 3.2.2. Захиалагч, түүний хөрөнгө оруулагчийн эрхэлж буй үйл ажиллагааг нотлох баримт бичгүүдийг хянан үзэх, эрх бүхий байгууллагаас лавлагаа авах;
- 3.2.3. Шаардлагатай тохиолдолд захиалагчийн үйл ажиллагаатай /Хуулийн этгээдийн удирдлага оршин байгаа газар, гол үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэлийн объект/ газар дээр нь танилцах;
- 3.2.4. Захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийг томилсон шийдвэрийг магадлах;
- 3.2.5. Захиалагчийн техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварыг нотолсон баримт бичгийг хянан үзэх;
- 3.2.6. Хайгуул, ашиглалтын ажилд зарцуулах хөрөнгийн баталгаа болгож ирүүлсэн санхүүгийн тайлан, харилцагч банк дахь харилцах дансны үлдэгдлийн тодорхойлолт, санхүүжилтийн бусад эх үүсвэрийн баталгааг /банкны баталгаа, мөнгө босгож буй үнэт цаасны бирж г.м./ хянах, эрх бүхий байгууллагаас лавлагаа авах, шаардлагатай



- тохиолдолд хөрөнгийн баталгаа гаргасан байгууллагуудтай уулзалт зохион байгуулах;
- 3.2.7. Хайгуул, ашиглалтын хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд газрын тос, уламжлалт бус газрын тосыг хайх, ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг тусгасан эсэх, төсөв нь төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэхэд хангалттай эсэхийг хянах, дүгнэлт гаргах;
- 3.2.8. Захиалагч нь түншлэл байвал тэдгээрийн хооронд гэрээ байгуулсан эсэх, талуудын эрх бүхий этгээдээс тодруулга авах;
- 3.2.9. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө нь хайгуулын хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөтэй нийцэж буй эсэх, өмнө явуулж байсан үйл ажиллагаатай холбогдуулан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ хэрхэн биелүүлж байсан талаар орон нутгаас лавлагаа авах;
- 3.2.10. Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцлийг Засгийн газарт хамгийн ашигтай байх талаар Захиалагчид санал тавьж, хэлэлцээ хийх;
- 3.3. Уулзалт, хэлэлцээ хийх бүрт тэмдэглэл хөтөлж, талуудын төлөөлөл гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.4. Ажлын хэсэг энэхүү журмын 3.2-т заасны дагуу хийж гүйцэтгэсэн ажлын талаар тогтоосон хугацаанд дүгнэлт гаргаж, Ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.5. Ажлын хэсэг нь тогтоосон хугацаанд захиалга, нэмэлтээр ирүүлсэн баримт бичиг, Ажлын хэсгийн дүгнэлт, уулзалтын тэмдэглэл, Захиалагчаас битүүмжлэн ирүүлсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцөлд өгсөн эцсийн саналыг багцлан лацдаж, Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргад актаар хүлээлгэн өгнө. Захиалагчийн битүүмжилсэн эцсийн саналыг Үнэлгээний хороо задлах эрхтэй.
- 3.6. Захиалагчаас битүүмжлэн ирүүлсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээний эцсийн саналд тусгагдсан үндсэн нөхцөлүүд нь хэлэлцээрийн үед Ажлын хэсэгт санал болгосон үндсэн нөхцөлүүдээс багагүй байна.
- 3.7. Төрийн захиргааны байгууллага, Ажлын хэсэг, Үнэлгээний хорооны гишүүд нь Газрын тосны тухай хуулийн 20.4-т заасан үүргийг хүлээнэ.
- 3.8. Сонгон шалгаруулалттай холбоотой бүх тэмдэглэл, бичиг баримтын эх хувийг Архивын тухай хуулийн дагуу хадгална.

#### 4. Сонгон шалгаруулалтын дүнг гаргах

- 4.1. Үнэлгээний хороо нь захиалгатай холбоотой баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 хоногт багтаан энэхүү журмын дагуу үнэлгээ хийж, сонгон шалгаруулалтын дүнг гаргана.
- 4.2. Үнэлгээний хороог 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.
- 4.3. Үнэлгээний хорооны гишүүнээр Ажлын хэсгийн гишүүнийг томилж болох боловч нэг Ажлын хэсэгт орсон 2-оос дээш гишүүн Үнэлгээний хороонд орж болохгүй.

- 4.4. Үнэлгээний хороо нь захиалга, түүнтэй холбогдсон баримт бичиг, Ажлын хэсгийн дүгнэлтийг хянан үзэж, үнэлгээ хийн, сонгон шалгаруулалтын дүнг гаргаж, ялагчийг тодруулан, санал, дүгнэлтээ илтгэх хуудсаар гаргана.
- 4.5. Сонгон шалгаруулалтын ялагчийг төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар баталгаажуулна.
- 4.6. Сонгон шалгаруулалтын дүнгийн талаар сонгон шалгаруулалтад оролцогчдод ажлын 5 хоногийн дотор мэдээлнэ.
- 4.7. Үнэлгээний хороо дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 4.7.1. Талбайн захиалга, нэмэлт баримт бичиг, Ажлын хэсгийн санал дүгнэлтийг хянан үзнэ. Үүнд:
- 4.7.1.1. Захиалга энэ журамд заасан шаардлага нөхцөлийг хангасан эсэх;
- 4.7.1.2. Ажлын хэсэг захиалгыг энэхүү журмын 3.2-т заасны дагуу шалгаж, холбогдох лавлагааг авч, дүгнэлт гаргасан эсэх;
- 4.7.2. Захиалгын иж бүрдэл дутуу, захиалгатай холбогдсон баримт бичиг нь энэ журмын 3.2-т заасны дагуу нотлогдоогүй материал, 3.6-д заасан шаардлагыг хангаагүй саналыг үнэлэхээс татгалзаж, энэ тухай Илтгэх хуудсанд тэмдэглэнэ.
- 4.8. Сонгон шалгаруулалтын үнэлгээний үзүүлэлт:
- 4.8.1. Ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хувь;
- 4.8.2. Нөөц ашигласны төлбөрийн хувь;
- 4.8.3. Өртөгт газрын тосны хязгаарын хувь;
- 4.8.4. Хайгуул, ашиглалтын хөрөнгө оруулалтын хэмжээ;
- 4.8.4.1. Захиалагчийн техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварыг нотлох баримт бичиг;
- 4.8.4.2. Хайгуул, ашиглалтын ажилд зарцуулах хөрөнгийн баталгаа;
- 4.8.4.3. Хайгуул, ашиглалтын хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсөв;
- 4.8.5. Байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ;
- 4.8.5.1. Хайгуул, ашиглалтын хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөтэй уялдуулан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө;
- 4.8.6. Сургалтын урамшууллын хэмжээ;
- 4.8.7. Гэрээнд гарын үсэг зурсны урамшууллын хэмжээ;
- 4.8.8. Олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ;
- 4.8.9. Олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ;
- 4.8.10. Орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ;
- 4.8.11. Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг;
- 4.8.12. Засгийн газарт санал болгох бусад ашигтай нөхцөл.
- 4.9. Захиалагчаас битүүмжлэн ирүүлсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцөлд өгсөн эцсийн саналыг үндэслэн үнэлгээний үзүүлэлтийг энэ

журмын тав ба зургаадугаар хавсралтын дагуу үнэлэх бөгөөд үзүүлэлт тус бүрээр оноог гаргаж, онооны дундаж дүнгээр эрэмбэлнэ.


- 4.10. Ажлын хэсгээс захиалга хүлээн авснаас хойш Үнэлгээний хороо холбогдох хавтас дахь бүх материал, баримт бичигт ямар нэг нэмэлт, өөрчлөлт оруулах буюу засварлахыг хориглоно.
- 4.11. Үнэлгээний хорооны хуралдааны тэмдэглэл, санал-дүгнэлт, үнэлгээний хүснэгтэд Үнэлгээний хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг санал өгсөн гишүүн бүр энэ тухайгаа Үнэлгээний хорооны дүгнэлтэд тусгана.
- 4.12. Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж дуусах хүртэл захиалга, түүнтэй холбогдсон бичиг баримтын хадгалалт, нууцлалт, хамгаалалтын асуудлыг хариуцна.

## 5. Маргаан шийдвэрлэх

- 5.1. Сонгон шалгаруулалтын талаар гарсан гомдлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

oOo





## ТАЛБАЙН ЗАХИАЛГА

### 1. Албан ёсны хүсэлт

(Газрын тосны газар)-ын дарга \_\_\_\_\_ танаа

[огноо]

.....улсын (компанийн нэр) нь нээлттэй сонгон шалгаруулалт зарласан .....талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул (ашиглалт)-тай холбогдсон үйл ажиллагаа явуулах хүсэлтэй байна.

Захиалагчийг төлөөлөх хүний овог, нэр, гарын үсэг, албан тушаал, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг

### 2. Захиалагчийн эрх зүйн байдлыг нотлох баримт бичиг;

- 2.1. Захиалагч, хөрөнгө оруулагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, бусад эрхийн гэрчилгээг наториатаар баталгаажуулсан хуулбар
- 2.2. Компанийн дүрэм
- 2.3. Бусад

### 3. Захиалагч, түүний хөрөнгө оруулагчийн танилцуулга

- 3.1. Захиалагчийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга
- 3.2. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга
- 3.3. Явуулж буй үйл ажиллагааг нотлох баримт бичгүүд /Нотариатаар баталгаажуулсан байх/

### 4. Захиалагчийг төлөөлөх хүний овог, нэр, албан тушаал, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг, түүнд эрх олгосныг нотлох баримт;

- 4.1. Захиалагчийг албан ёсоор төлөөлөх этгээдэд ТУЗ, болон хувьцаа эзэмшигчийн хурлаас эрх олгосон шийдвэр (итгэмжлэл)

### 5. Захиалагчийн техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварыг нотлох баримт бичиг;

- 5.1. Захиалагч нь газрын тос, уламжлалт бус газрын тосны мэргэжлийн байгууллага бол гүйцэтгэсэн ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нотлох баримтууд,
- 5.2. Захиалагч нь газрын тос, уламжлалт бус газрын тосны мэргэжлийн бус байгууллага бол мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах талаар

гэрээ, санамж бичиг байгуулсан байх бөгөөд харилцан хүлээх эрх, үүргийн талаар тодорхой тусгана,

- 5.3.** Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд ашиглахаар санал болгож буй технологи, техник, тоног төхөөрөмжийн танилцуулга,

**6.** Хайгуул /ашиглалт/-ын ажилд зарцуулах хөрөнгийн баталгаа

- 6.1.** Захиалагч, хөрөнгө оруулагчийн аудитаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан,  
**6.2.** Захиалагч, хөрөнгө оруулагчийн харилцагч банк дахь харилцах дансны захиалга ирүүлэхийн өмнөх сарын үлдэгдлийн тодорхойлолт,  
**6.3.** Санхүүжилтийн бусад эх үүсвэрийн “баталгаа”

- 7.** Хайгуулын хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийг Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журмын хоёрдугаар хавсралтын дагуу, Ашиглалтын хугацаанд хийж гүйцэтгэх орд ашиглалтын урьдчилсан төлөвлөгөөг “Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага”-ын дагуу,

- 8.** Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцөлд өгөх саналаа Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журмын гуравдугаар хавсралтын дагуу,

- 9.** Хайгуул /ашиглалт/-ын хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөтэй уялдуулан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөг Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу,


- 10.** Захиалагч нь түншлэл байвал түүний оролцогч талуудын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, оролцох хувь, хэмжээ,

- 11.** “Хайгуул, ашиглалтын талбайн захиалга”-ын үйлчилгээний хөлс төлсөн баримт,

- 12.** Геологийн багц материал худалдан авсан баримт.



Уул уурхайн сайдын  
2014 оны ..~~2012~~ дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт




**ХАЙГУУЛЫН ХУГАЦААНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ**

Хайгуулын жил	Хайгуулын ажлын нэр, төрөл	Ажлын доод хэмжээ	Зардал (ам.доллар)
1 дэх жил			
	Нэг дэх жилийн хайгуулын ажлын нийт зардал		
2 дахь жил			
	Хоёр дахь жилийн хайгуулын ажлын нийт зардал		
3 дахь жил			
	Гурав дахь жилийн хайгуулын ажлын нийт зардал		
4 дэх жил			
	Дөрөв дэх жилийн хайгуулын ажлын нийт зардал		
5 дахь жил			
	Тав дахь жилийн хайгуулын ажлын нийт зардал		
6 дахь жил			
	Зургаа дахь жилийн хайгуулын ажлын нийт зардал		
7 дахь жил			
	Долоо дахь жилийн хайгуулын ажлын нийт зардал		
8 дахь жил			
	Найм дахь жилийн хайгуулын ажлын нийт зардал		
Нийт зардал			

**БХГ-НИЙ ҮНДСЭН НӨХЦЛҮҮДЭД ӨГӨХ САНАЛ**

Хуулийн үндэслэл	БХГ-ний үндсэн нөхцлүүд	.....ХХК-иас санал болгож буй нөхцөл		
		Баррель	Засгийн газар	Гэрээлэгч
17.3.1	Ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хувь	Өдрийн олборлолтын хэмжээ 5000 баррельтай тэнцүү буюу түүнээс бага бол		
		Өдрийн олборлолтын хэмжээ 5000 баррелиас их 10000 баррельтай тэнцүү бол		
		Өдрийн олборлолтын хэмжээ 10000 баррелиас их 15000 баррельтай тэнцүү бол		
		Өдрийн олборлолтын хэмжээ 15000 баррелиас их бол		
17.3.2	Нөөц ашигласны төлбөрийн хувь	..... % тогтмол		
17.3.3	Өртөгт газрын тосны хязгаарын хувь	..... %		
17.3.4	Хайгуулын хөрөнгө оруулалтын хэмжээ	ам.доллар		
17.3.5	Байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ	1 дэх жил	ам.доллар	
		2 дахь жил	ам.доллар	
		3 дахь жил	ам.доллар	
		4 дэх жил	ам.доллар	
		5 дахь жил	ам.доллар	
		6 дахь жил	ам.доллар	
		7 дахь жил	ам.доллар	
		8 дахь жил	ам.доллар	
17.3.6	Сургалтын урамшууллын хэмжээ /жил бүр/	ам.доллар		
17.3.7	Гэрээнд гарын үсэг зурсны	ам.доллар		



	урамшууллын хэмжээ /нэг удаа/	
17.3.8	Олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ /нэг удаа/	ам.доллар
17.3.9	Олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ	Өдрийн олборлолтын хэмжээ 5000 баррелиас их тохиолдолд ..... ам.доллар Өдрийн олборлолтын хэмжээ 10000 баррелиас их тохиолдолд ..... ам.доллар Өдрийн олборлолтын хэмжээ 15000 баррелиас их тохиолдолд ..... ам.доллар
17.3.10	Орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ /жил бүр/	ам.доллар
17.3.11	Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг /жил бүр/	ам.доллар
17.3.12	Засгийн газарт санал болгох бусад ашигтай нөхцөл	ам.доллар



Уул уурхайн сайдын  
2014 оны ... дугаар тушаалын  
тавдугаар хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛ,  
ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ**

Хайгуулын жил	Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил	Зардал (ам.доллар)
1 дэх жил		
2 дахь жил		
3 дахь жил		
4 дэх жил		
5 дахь жил		
6 дахь жил		
7 дахь жил		
8 дахь жил		
<b>Нийт</b>		







СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

Уул уурхайн сайдын 2014 оны ... дугаар тушаалын долоодугаар хавсралт

д/д	Сонгон шалгаруулалтын үнэлгээний үзүүлэлтүүд	Үнэлгээ хийх аргачлал	Үнэлгээ хийх итгэлцүүр, өгөх дээд оноо	Захилагч ...		Захилагч ...		Захилагч ...		Захилагч ...		
				Санал	Дундаж оноо	Санал	Дундаж оноо	Санал	Дундаж оноо	Санал	Дундаж оноо	
1	Ашигт газрын тосны Монгол улсын Засгийн газарт ногдох хувь /Хуулийн 17.3.1 заалт/	Өдрийн олборлолтын хэмжээ 5000 баррелтай тэнцүү буюу түүнээс бага бол	40% бол 0 оноо, 40%-иас дээш хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлж нэмэх оноо, 40% доош хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлж хасах оноо өгнө	-								
		Өдрийн олборлолтын хэмжээ 5000 баррелиас их 10000 баррелтай тэнцүү бол	40% бол 0 оноо, 40%-иас дээш хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлж нэмэх оноо, 40% доош хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлж хасах оноо өгнө	-								
		Өдрийн олборлолтын хэмжээ 10000 баррелиас их 15000 баррелтай тэнцүү бол	40% бол 0 оноо, 40%-иас дээш хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлж нэмэх оноо, 40% доош хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлж хасах оноо өгнө	-								
		Өдрийн олборлолтын хэмжээ 15000 баррелиас их бол	40% бол 0 оноо, 40%-иас дээш хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлж нэмэх оноо, 40% доош хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлж хасах оноо өгнө	-								
		<b>Дундаж оноо</b>										
		5-15 хувь байна /Хуулийн 31.1 заалт/	5% бол 0 оноо, 5%-иас дээш хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлнэ	-								
2	Нөвц ашигласны төлбөрийн хувь (%) /Хуулийн 17.3.2 заалт/	40 хүртэл хувь байна /Хуулийн 32.3 заалт/	40% бол 0 оноо, 40%-иас доош хувь бүрийг итгэлцүүрээр үржүүлнэ	-								
3	Өртөгт газрын тосны хязгаарын хувь /Хуулийн 17.3.3 заалт/	Хайгуул (ашиглалт)-ын хүлээн авч хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсөв /Хуулийн 20.2.6 заалт/	Жуурын хоёрдугаар хавсралтын дагуу хийж гүйцэтгэх ажил, хөрөнгө оруулалтын хэмжээнд үндэслэн .... хүртэл оноо	0 - ... хүртэл								
4	Хайгуул (ашиглалт)-ын хөрөнгө оруулалтын хэмжээ /Хуулийн 17.3.4 заалт/	Захиалагчийн техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварыг дараах үзүүлэлтүүдийн аль нэгээр нь үнэлэх /Хуулийн 20.2.4 заалт/	Газрын тос, уламжлалт бус газрын тосны мэргэжлийн бус байгууллага боловч хайгуул (ашиглалт)-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагатай түншлэл бол .... хүртэл оноо	0 - ... хүртэл								
		Хайгуул (ашиглалт)-ын ажилд зарцуулах хөрөнгийн баталгаа /Хуулийн 20.2.5 заалт/	Газрын тос, уламжлалт бус газрын тосны мэргэжлийн бус байгууллага боловч хайгуул (ашиглалт)-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах талаар гэрээ, санамж бичиг байгуулсан бол .... хүртэл оноо	0 - ... хүртэл								
<b>Нийт оноо</b>												

Сонгон шалгаруулалтын үнэлгээний харьцуулалт

